



**“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ийн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 8 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар ТУЗ2026-03/05

Улаанбаатар
хот

Зөвшөөрөл олгох, гарын үсэг зурах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1 дэх хэсгийн 76.1.17, 76.1.18, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалтыг болон “Жуулчин дюти фрий” ХХК /цаашид “Компани” гэх/-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.8 болон 8.8.17 дахь заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 70.94%-ийн хувьцаа эзэмшигч болох “Таван Богд Холдингс” ХХК нь “Азийн Хөгжлийн Банк” /цаашид “АХБ” гэх/-тай 30,000,000 /гучин сая/ ам.доллартай тэнцэх төгрөг хүртэлх дүн бүхий зээлийн гэрээ байгуулахаар шийдвэрлэснийг дурдсугай.
2. 2026 оны 01-р сарын 01-ний өдөр Компани болон “Таван Богд Холдингс” ХХК нарын хооронд байгуулагдсан Зээлийн шугамын гэрээний дагуу зээлдүүлэгчийн хувиар Компанийн эдлэх аливаа шаардах эрх, төлбөрийн шаардлагыг энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан АХБ-с “Таван Богд Холдингс” ХХК-д олгох зээлтэй холбоотой АХБ-ны аливаа шаардах эрх, төлбөрийн шаардлагын дараа эрэмбэлэх тохиролцоо хийж, шаардах эрхийн дараалал хойшлуулах тухай гэрээ (Deed of Subordination)-г АХБ болон “Таван Богд Холдингс” ХХК-тай байгуулахыг Компанид үүгээр тус тус зөвшөөрсүгэй.
3. Энэхүү тогтоолын 2 дахь хэсэгт заасан шаардах эрхийн дараалал хойшлуулах тухай гэрээний нөхцөл, агуулгыг Компанийн нэрийн өмнөөс хэлэлцэн тохиролцох, улмаар тус гэрээнд Компанийг төлөөлж гарын үсэг зурж, баталгаажуулах, гэрээтэй холбоотой мэдэгдэл, гэрчилгээ, маягт, хавсралт болон бусад баримт бичигт гарын үсэг зурах, холбогдох төлбөр тооцоог хийх эрхийг дангаар эсвэл хамтран хэрэгжүүлэх эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал /Ц.Отгонбаяр/, “Таван Богд Холдингс” ХХК-ийн Санхүү удирдлага хариуцсан захирал /Б.Оргил/ нарт тус тус олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:

Д.УЯНГА

Д.БОЛОРМАА

Д.БАЙГАЛМАА

